



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 353

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газарт орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон 34,900,000 (гучин дөрвөн сая есөн зуун мянга) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газрын дарга Ж.Ганболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн  
353 дугаар тогтоолын нэг дүгээр хавсралт

Говь-Алтай аймаг дахь Шүүхийн тамгын газрын дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ(төгрөг)	Хуриутлагдсан элэгдэл(төгрөг)	Үлдэх өртөг(төгрөг)
1	Тоёота Приус альфа-41	2023	1	Ш	34,900,000	-	34,900,000
Нийт					34,900,000	-	34,900,000
					(гучин дөрвөн сая есөн зуун мянга)	(тэг)	(гучин дөрвөн сая есөн зуун мянга)